



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 117

Эрдэнэт

“Хүндэт иргэн”  
шагналаар шагнах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 120 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрдэнэт хотын өдрийг тохиолдуулан аймаг, орон нутгийн түүхэн хөгжил, бүтээн байгуулалтад оруулсан онцгой хувь нэмрийг нь үнэлж Даваадоржийн Оюунбат, Осорын Гүндэгмаа, Баатарын Мянганбаяр нарыг Эрдэнэт хотын “Хүндэт иргэн” шагналаар шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах хөрөнгийг аймгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга С.Батжаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХБАТ